

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Пүрэв, 2019.10.10, №2 (118)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.jargaldefacto.com

WEEKLY



ДеФакто **НИЙТЛЭЛ**
№500

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

Тав дахь үеийн ТАВАРГААН



БОЛОВСРОЛ

Б.Насанбаяр
Ph.D /Боловсрол судлал/

БАГШ

НАРЫН “БАЯР”

III НҮҮРТ

НИЙТЛЭЛ

НҮҮБ БОЛОН Сэтгүүлчийн эрх чөлөө

VI НҮҮРТ

ДеФакто **ТОЙМ**

➤ УИХ –ЫН НАМРЫН
ЧУУЛГАНЫ НЭЭЛТ БА
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХОРИГ

➤ ИТГЭЛИЙН ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

➤ ЖИНХЭНЭ ЖДҮ–ЧИД
ЯЛАГДЛАА

VIII НҮҮРТ



Гар утас монголчуудын амьдралд хувьсгалт өөрчлөлт авчирсныг бид түүнийг өдөр тутам, тасралтгүй хэрэглэж байгаа мөртлөө анзаардаггүй. Гар утас бидний оршин тогтнохын бүрэлдэхүүн хэсэг нэгэнт болчихсон учир хэн ч өнөөдөр амьдралаа тэр утасгүйгээр төсөөлж чадахгүй боллоо.

Тэгвэл энэ хувьсгалын хөдөлгөгч хүч нь харилцаа холбооны өрсөлдөөнт зах зээл, тасралтгүй дэвшин хөгжиж буй тоон мэдээлэл дамжуулах технологи юм. Монголын гар утасны анхны оператор компани Мобиком 1996 онд ажиллаж эхэлснээс хойш Скайтел, Жи-Мобайл, Юнител зэрэг компаниуд байгуулагдан, энэ зах зээл дээр өрсөлдөж монголчуудад үйлчилгээ хүргэсээр байна.

Одоо дараагийн үе - 5G ирж байна. Энэ үеийн технологийг Монгол улс хэзээ ашиглаж эхлэх вэ, гайхамшигт шинэ боломжуудыг ашиглахад бид бэлэн үү, энэ үеийг 4G-гээс өгөөжтэй, авхаалжтай ашиглах ямар арга зам байна вэ?

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ҮЕҮД

Харилцаа холбооны технологид огцом өөрчлөлт гарч хүмүүний амьдралд хувьсгал хийсээр байна. Энэ үсрэнгүй өөрчлөлтийг 1G, 2G, 3G, 4G гэж үе үеэр нь нэрлэдэг. Утасгүй холбооны технологийн эдгээр үеүд нь мэдээлэл дамжуулах хурд, технологи, давтамж, чадлаараа эрс ялгаатай. 1G нь аналог систем буюу зөвхөн дууг, 2G тоон системд шилжиж, дуунаас гадна үсэг (message) дамжуулдаг болов. 3G нэмж дүрс (video), харин 4G болохоор интернет оруулж ирсэн бөгөөд шинэ үе бүр шинэ бүтээмжийг дагуулсан.



▶ Харин одоо зарим оронд хэрэгжүүлж эхэлсэн, төдөлгүй монголд орж ирэх дараагийн үе - 5G технологи бидний төсөөлж байгаагүй, өргөн боломж олгох ажээ. Энэ бол бүх зүйл интернеттэй (Internet of Things) холбогдож, төхөөрөмжүүд хоорондоо хүнгүйгээр харилцан, ойлголцож, үйлдэл хийж, замын хөдөлгөөнд жолоочгүй машин хэрэгслүүд оролцож, мэс заслыг робот хийх зэргээр хиймэл оюун ухаан хүний олон ажлыг орлон гүйцэтгэх шинэ

эрин ирж байна гэсэн үг.

Тав дахь үеийн сүлжээ бол маш өндөр хурдтай, мэдээлэл дамжуулах хоцролт багатай, тогтвортой холболттой учир өмнөхөөсөө давуу талтай. 4G-гийн дохионы давтамж нь дээд тал нь 2.4 GHz (Херц гэдэг нь нэг секундэд давтагдах долгионы үеийг хэлдэг), харин 5G нь 3.5 – 24 GHz хүрдэг. Жишээ нь, Ойролцоо яваа машины хурдны өөрчлөлтийг таны машин 4G-гээр дамжуулахад 15-25 секунд,

харин 5G-гээр 1 миллисекундын дараа, бараг зэрэг мэдэрнэ. Гэхдээ 24GHz, өндөр давтамжтай 5G-гийн долгион нь 100 метрээс хол зай туулж чаддаггүй учир маш олон дамжуулах станц барих шаардлагатай юм. Өмнөд Солонгос улс 2019 оны 4-р сараас анх 5G сүлжээг өргөн хүрээнд ашиглаж эхэлсэн бол АНУ, БНХАУ, Япон зэрэг улсууд энэ зах зээл рүү хүч түрэн орж байна.

БОЛОМЖ БА МОНГОЛ

Монгол шиг далайд гарцгүй орны шинэ үед дэлхийн зах зээл дээр гэрээсээ гарах өргөн боломж ороод ирж байгаа хэрэг юм. 5G-гийн хэрэглэгч гар утсандаа датаг одоогийнхоос дор хаяж 30 дахин хурдтай хүлээн авч, сэтгэл ханамж өндөр болно. Мөн бүхий л төхөөрөмж сүлжээнд холбогдсоноор, асар их хэмжээний мэдээллийг авах, дамжуулах, хадгалах, боловсруулах боломж бүрдэнэ.

Олон тоног төхөөрөмж сүлжээнд холбогдоход бүх үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт автоматжуулалт өрнөнө.

Тодруулбал, DBS Group-ын судалгаагаар дэлхий даяар 2018 онд интернеттэй холбогдсон 11 тэрбум тоног төхөөрөмж байсан бол, 5G-гийн ачаар 2030 он гэхэд 125 тэрбум болох гэнэ. Энэхүү автоматжуулалт нь бүтээмжийг нэмэгдүүлж, ашгийн үзүүлэлтүүдийг 9 хувиар өсгөх гэнэ.

Монгол улсад 5G технологи одоо байгаа дамжуулах станцаас 10 дахин олныг барих шаардлага гарах учраас 4G-тэй харьцуулахад бараг 10 дахин их хөрөнгө оруулалт шаардана. Монголд 80,000 аж ахуйн нэгж бүртгэлтэйгээс 60,000 нь жижиг дунд үйлдвэрлэл

эрхлэгчид ба ажиллах хүчний 43%-ийг ажиллуулж, экспортын ердөө л 2.3 хувийг бүрдүүлдэг. Тиймээс 5G-г том аж ахуй нэгжүүд нь ашиглаж, харин ЖДҮ нь хоцрох магадлал өндөр.

Нөгөө талаас монголчууд худал, хуурамч мэдээллээс өөрсдийгөө хамгаалж чадахгүй байгаа. Асар их мэдээллийн сан руу үсрэхээс өмнө бид хувь хүний болон улс орны аюулгүй байдалтай холбоотой мэдээллээ яаж хамгаалах тухай учраа олж, хууль журмаа хэрэгжүүлэх шаардлагатай даа.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ЦАГ ХУГАЦАА

Монгол улсын үүрэн холбооны дөрвөн оператор тус бүртээ өөр өөрийн дэд бүтэц байгуулж ирлээ. Энэ нь хувьдаа зам бариад зөвхөн өөрийнхөө машиныг явуулахтай адил бөгөөд тийм ч учраас хэрэглэгчийн төлбөр буурч чадахгүй байна. 4G технологийг оруулахад Юнител компани дангаараа 2016 оноос хойш 120 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн учир түүнийгээ нөхөхөд хугацаа шаардлагатай.

Мобиком ч бас адил. Харин 5G сүлжээний дэд бүтцийг явал хурдан, хэрэглэгчид харьцангуй хямд хүргэх талаар монголын нийгэмд ярилцах шаардлага гарч байна. Өнөөг хүртэл явсан хэлбэрээ үргэлжлүүлнэ гэвэл асар том хөрөнгө оруулалт өгөөжгүй, зардал улам бүр ихсэж, технологийн шинэчлэлийг монголд нэвтрүүлэх хугацаа улам бүр хойшилсоор байх юм.

**НЭГДСЭН НЭГ ДЭД БҮТЭЦ
БАЙГУУЛААД, ХАМТРАН
АШИГЛААД ЯВАХАД ЮУ
СААД БОЛЖ БУЙГ
ХЭЛЭЛЦЭХ ЦАГ БОЛЖЭЭ.
МОНГОЛД ӨМНӨХ ҮЕИЙН
БҮХ ТЕХНОЛОГИ БУСАД
ОРНООС НЭЛЭЭН ХОЖИГДОН
'ТАВАРГАЖ' ИРДЭГ НЬ ЭНЭ
УДАА БАС Л ДАВТАГДАХ УУ?**


2019.10.10




НИЙТЛЭЛ

Б.НАСАНБАЯР

Ph.D /Боловсрол судлал/



БАГШ НАРЫН “БАЯР”



ЮНЕСКО, Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай хамтран 1966 онд Багш нарын статусын тухай Засгийн газар хоорондын тусгай бага хурал зохион байгуулж (Special Intergovernmental Conference on the Status of Teachers) “Багш нарын статусын тухай зөвлөмж”-ийг (The ILO/ UNESCO Recommendation concerning the Status of Teachers) батлан гаргасан юм. Уг зөвлөмж нь багшийн мэргэжлийн олон улсын стандартыг тодорхойлж өгсөн. Мөн 1997 оны 10-р сард ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 29-р чуулганаар “Их дээд сургуулиудын багш нарын статусын тухай зөвлөмж”-ийг (The UNESCO Recommendation concerning the Status of Higher-Education Teaching Personnel) батлан гаргасан байдаг.

БАГШ НАРЫН ӨДӨР

ЮНЕСКО-гоос жил бүрийн он хүртэл жил бүрийн хоёрдугаар байхаар Засгийн газраас “Түүхэн 10-р сарын 5-ны өдрийг Дэлхийн сарын эхний ням гаригт үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг багш нарын өдөр болгон 1994 тэмдэглэж ирсэн. Харин 2014-2015 тэмдэглэх, гавьяат үйлстнийг онд зарласан. Жил бүр ЮНЕСКО- оны хичээлийн жилээс Монголын алдаршуулах, дурсгалыг нь гийн санаачилгаар Дэлхийн багш багш нарын өдрийг жил бүрийн мөнхжүүлэх” журамд өөрчлөлт нарын өдрийг тэмдэглэдэг нь 10-р сарын 5-нд Дэлхийн багш оруулсан. дэлхийн өнцөг булан бүрт багш нарын өдөртэй хамт тэмдэглэж нарт талархал илэрхийлэх, тэдний хөдөлмөрийг үнэлэх, багш нарын энэхүү хариуцлагатай мэргэжилд олон түмний анхаарлыг хандуулах, багшийн нэр хүндийг өргөх, улс орны хөгжил цэцэглэлтэд багш нарын гүйцэтгэж буй үүрэг оролцоо, тулгарч буй асуудал бэрхшээлийг шийдэхэд анхаарал хандуулах зорилготой юм.

Монголын багш нарын өдрийг 1967 оноос 2013

2019 оны Дэлхийн багш нарын өдрийг ЮНЕСКО “Залуу багш нар: Багш мэргэжлийн ирээдүй (Young Teachers: The future of the Profession)” уриатайгаар тэмдэглэн, залуус багш мэргэжлийг сонгох боломж бүрдүүлэхийг Засгийн газруудад уриалж, тогтвортой хөгжлийн 4-р зорилтыг амжилттай хэрэгжүүлж, чанартай боловсрол олгоход багш нарын үүргийг онцолж байна.



▶ **БАГШ САЙН, БОЛОВСРОЛ ЧАНАРГҮЙ**

2013 онд ЮНЕСКО-гоос “Сургалтанд юу чухал ач холбогдолтой вэ? Сургалтын үр дүнг хэрхэн хэмжих вэ? Боловсролын чанарыг хэмжих аргыг яаж сайжруулах вэ?” гэсэн асуултанд анхаарлаа хандуулахыг уриалсан байдаг. Мөн “Хүүхэд бүр зөв арга барилаар суралцаж, ирээдүйд бэлтгэгдэж чадаж байна уу?” гэсэн асуултыг боловсролын байгууллага, багш нар өөртөө тавихыг судлаачид зөвлөсөөр байна.

Ажилдаа амжилт гаргах, амьдралаа чанартай удирдахад шаардлагатай мэдлэг, чадвар, хандлагыг эзэмших XXI зууны

боловсролын тогтолцооны үзэл баримтлал, сургалтын хамрах хүрээг P21 түншлэлийн холбоо

1. Амьдрах ухаан, мэргэжлийн чадвар
2. Суралцах, шинэчлэх чадвар
3. Мэдээллийн хэрэгсэл, технологийн чадвар гэж 3 багцалсан байдаг.

Гэтэл эдгээр чадварт Монгол багш нар хэрхэн бэлтгэгдсэн, хэрхэн хөгжүүлэх шийдэлд анхаарал хандуулахаас илүүтэй эрдэмтэн, багш нар жил бүр “анхдугаар” нэртэй хэлбэрдэлт нь дэндсэн чуулганд мянга мянгаараа

цугларч, Ерөнхий сайдынхаа дуулахад уярч, баясахаас хэтрэхээ байв. “Хүргэн хүү” киноны Жамц баяны хэлдгээр “Дэмбэрэл хөөрхий юм үзээгүй юм болохоор...” гэдэг шиг “цалин нэмнэ, ачаалал багасгана” гэхээс өөрийг үл амлагч хоноцын сэтгэлтэй улс төрчдөд багш нар хэдий хүртэл хууртсаар байх вэ? Монгол улсын дайтай улс болоход хүн нь хөгжих учиртай, хүн нь хөгжихийн тулд багш нар хүүхэд бүрийн төлөө “ачаалал” авч байж л боловсролд чанар ирнэ. Хууран өргөмжлөх үед “багш” шиг сайн хүн үгүй, муулж буруутгах үед “боловсрол” шиг чанаргүй зүйл үгүй.

Хичээл, сургалтын үйл ажиллагааны өдөр бүрийн үйл явцад

1. Идэвхтэй сургалтын арга хэрэглэх
2. Багшлах, суралцахуйн туршлага хуримтлуулах боломж бүрдүүлэх
2. суралцагч бүрийн суралцахуйн чадвар үйл явц харилцан адилгүй гэдэг зарчмыг хэрэгжүүлэх боломж, нөхцөл бүрдүүлэх нь чухал. Гэтэл боловсролын салбарынхан улс төрөөс хараат бус байх, хүүхэд бүрийн хөгжих эрхийн төлөө хэлэлцдэг, сайн туршлагаа хуваалцдаг соёлд суралцахад “Дэлхийн болон Монголын багш нарын өдөр”-ийг ашиглахаас илүү цэцэг, шагналд бялуурч өнгөрүүлдэг нь гэм биш зан болжээ. Багш нарт хүртээж буй хүндэтгэл, цол хэргэм, шагналтай боловсролын чанар, чансаа, үүрэг, хариуцлагын хамаарлыг харьцуулан дүгнэвэл багш сайн, боловсрол чанаргүй гэж тодорхойлж болох байна.

БАГШИЙН УР ЧАДВАР

Багшийн ур чадвар гэдэг нь хүүхэд бүрийг хайрлан хүндлэх чин сэтгэлийн хандлага, бүтээлчээр сургалтын үйл явцыг удирдах мэдлэг, чадвар юм. Багшийн ур чадварын тусгал нь хүүхэд аз жаргалтай суралцах сайн хичээлийн үйл явц. Сайн хичээл гэдэг бол “багш хичээнгүйлэн заадаг хичээл бус, суралцагч дуртай, хичээнгүйлэн суралцдаг хичээл” юм. Сайн хичээлд хүүхэд бүр тасралтгүй оролцож, хамтарч, бүтээлч үйлдлээрээ сорилт, бэрхшээлийг даван гарч өөрийн үнэ цэнийг мэдэрч, асуудал шийдвэрлэх итгэл найдварыг хүүхэд өөрөө өөртөө бүтээдэг аз жаргалтай суралцах үйл явц. Гэтэл “Би 200 гаруй хүүхдэд хичээл ордог.

Хүүхэд бүрийг хөгжүүлж чадахгүй” гэдэгт итгэл төгс багш нар цөөнгүй. Хөгжүүлэх боломжгүй гэж харсан хэсэг дотор таны, миний хүүхэд байвал тэдний ирээдүй хаачих вэ?

Багшлах, суралцахуйн мөн чанарыг “Хүн асуудлыг шийдвэрлэхэд суралцсан байвал бэрхшээл, асуудал бүхий, байнга өөрчлөгдөж байдаг дэлхий ертөнцөд аж төрөхөд илүү сайн бэлтгэгдэнэ” (UNESCO Education Strategy, 2014–2021) гэж тодорхойлсон байдаг. “Амьдрал бүхэлдээ асуудал шийдвэрлэлт юм” (Karl Popper, 1999) гэж тодорхойлсон нь ч байна. Жилд ганц тохиодог асуудлаа хэлэлцэж шийдэл хайх боломжтой багш нарын өдрөөрөө баярлаж, цэнгээд өнгөрч буй боловсролын байгууллагуудын хичээл, үйл ажиллагаанд “асуудал шийдвэрлэгч хүнийг бэлтгэх” соёл бүрдэхэд их л цаг орно байх. Гэхдээ сайн хичээл бэлтгэн, удирдах чадвартай багш нарт бол өдөр бүр ЖИНХЭНЭ БАЯРЫН өдөр байдаг.

ЗАЛУУ БАГШ НАР: БАГШ МЭРГЭЖЛИЙН ИРЭЭДҮЙ

2018-2019 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД

	Ажилласан жил	Хувиар
Улсын хэмжээнд ерөнхий боловсролын нийт 803 сургуульд 30411 багш ажиллаж байна.	1	6%
	1-5	31.8%
	6-10	18.9%
	11-15	15.9%
	16-20	10.1%
	21-25	5.1%
	25-дээш	11.3%

10 хүртэлх жил ажилласан туршлагатай 56.7%

	Ажилласан жил	Хувиар
Улсын хэмжээнд нийт 1435 цэцэрлэгт 7843 үндсэн багш ажиллаж байна.	1	17.9%
	1-5	48.4%
	6-10	15.4%
	11-15	7.7%
	16-20	3.6%
	21-24	1.9%
	25-дээш	5.1%

10 хүртэлх жил ажилласан туршлагатай 81.7%

2019 оны Дэлхийн багш нарын өдрийн ЮНЕСКО-гийн уриалгад дүйцэхүйц шийдлийг 2014 онд Н.Алтанхуягийн Засгийн газар багш бэлтгэдэг төрийн өмчийн Их дээд сургуульд 650, 750 дээш оноо авсан элсэгчдэд 70, 100 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг болон хөдөө орон нутагт багшлах дадлагын амьжиргааны зардлыг 100 хувь сургалтын төрийн сангаас олгох шийдвэр гаргасан байдаг.

Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 56.7 хувь, цэцэрлэгийн багш нарын 81.7 хувь нь 10 хүртэл жил ажилласан залуу багш нар байгаа нь манайд маш том боломж, бас зөв шийдэл хүлээсэн бодит байдал юм. Залуу болон нийт багш нарын мэргэжлийн ур чадвар иргэн бүрт “Идэвхтэй, бүтээлч, насан туршдаа суралцах чадвар олгож чадаж байна уу?” гэдгийг судалдаг, бодлогын дэмжлэг туслалцааг тодорхойлдог эрдэмтэн судлаач, мэргэжлийн байгууллагын манлайлал үгүйлэгдсээр байна.

2019 оны 10-р сар

“ЭРХ ЧӨЛӨӨ”

ГУРВАЛ НОМ

Интерном номын дэлгүүрийн бүх салбаруудаар худалдаалагдаж байна.

+(976) 9410 9342

НҮБ БОЛОН

Сэтгүүлчийн эрх чөлөө


НҮБ -ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААН ДАХЬ ТАЙВАНИЙН ОРОЛЦОО

Тайвань 1974 онд НҮБ-ын гишүүнчлэлийн эрхээ хасуулснаас хойш НҮБ болон түүний системийн байгууллагуудын төрөл бүрийн хурал чуулган, гэрээ конвенц болон үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон байна. 1993 оноос хойш Тайвань, ард иргэдийн сайн сайхан, улс орны хөгжлийн төлөөх НҮБ-ын системийн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцох асуудлаар олон улсын дэмжлэгийг эрэлхийлсээр иржээ.

НҮБ ДАХЬ ТАЙВАНИЙН ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ

НҮБ хүний эрхийг түгээн тунхаглах, ардчилсан сайн засаглалыг дэлгэрүүлэгч хамгийн чухал олон улсын байгууллагуудын нэг төдийгүй хэвлэл мэдээллийн ажилтнуудын мэдээ, сурвалжлага бэлтгэх эрх, эрх чөлөөг хангаж, хүндэтгэлтэй хандсаар ирсэн. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө бол ардчилсан засаглалын хамгийн чухал үндэс бөгөөд "Хүний эрхийн түгээмэл тунхаг бичиг" /Universal Declaration of Human Rights/-т багтсан хүний нийтлэг чухал эрхүүдийн нэг. Сэтгүүлчийн мэдээ, сурвалжлага авах эрх нь ард иргэдэд үнэн зөв мэдээ, мэдээлэл хүргэх; ардчилсан засаглалын хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс ард нийтийн эрх ашгийн төлөө төрийн эрх мэдэлтнүүдтэй хариуцлага тооцох үйл явцад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Тайвань хэвлэл мэдээллийн эрх, эрх чөлөөг дээдэлдэг, хэвлэл мэдээллийн салбар нь мэргэжлийн түвшинд хүрч хөгжсөн ардчилсан орон. Одоогийн байдлаар Тайванийн сурвалжлагч, сэтгүүлч болон хэвлэл мэдээллийн ажилтан, албан хаагчид нь НҮБ-аас сэтгүүлчийн үнэмлэх хүсэлт гарган авч, НҮБ-ын холбогдох хурал чуулганы тухай мэдээ, сурвалжлага бэлтгэх боломжгүй байгаа нь эрх тэгш бус, ялгаварлан гадуурхагдаж хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөөг зөрчсөн, даян дэлхийн ардчилсан сайн засаглалд таагүй нөлөө үзүүлж байгаа хэрэг юм.




Ranking since 2013

Year	Ranking		Year	Ranking	
2018	42 / 180	↑	2014	50 / 180	↓
2017	45 / 180	↑	2013	47 / 180	=
2016	51 / 180	=			
2015	51 / 180	↓			

CLOSE THIS WINDOW

Эх сурвалж:
www.rsf.org



Taiwan

● FREE

93/100



Aggregate Freedom Score



Эх сурвалж:
www.freedomhouse.org

“Хил хязгааргүй сэтгүүлчид” (RSF) байгууллагын ерөнхий нарийн бичгийн дарга Кристоф Делуар / Christophe Deloire/ хэлсэн үгэндээ “НҮБ-аас Тайванийн сурвалжлагч, сэтгүүлчдийг мэдээ сурвалжлага бэлтгэхийг хориглосон нь “Хүний эрхийн түгээмэл тунхаг бичиг”-ийн 19-р зүйлийг зөрчиж байна.”

гэв. Мөн Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ) энэ оны 6-р сард болсон 30 дахь удаагийн Нэгдсэн Ассамблейн үеэр 12-р онцгой тогтоолын төслөө баталсан. Үүндээ “НҮБ-ын зүгээс Тайванийн сурвалжлагч, сэтгүүлчдийг ялгаварлан гадуурхах бодлогоо эцэслэж, сэтгүүлчдэд шахалт

үзүүлж буй үйлдлээ зогсоон, НҮБ-ын системийн байгууллагад элсэх өргөдөл гаргагчдын паспортыг зөвхөн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн нэгдсэн хуралдаанаас итгэмжилсэн улс орноос гаргасан байх ёстой гэсэн шаардлагыг нэн даруй цуцлах нь зүйтэй” гэжээ.

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХ НЬ

Нэгдсэн Байгууллагаас Тогтвортой хөгжлийн зорилтууд нь “Хэнийг ч орхигдуулахгүй байх” /Leave no one behind/ гэх зарчмын хүрээнд дэлхийн улс орнуудыг тогтвортой хөгжилд удирдан чиглүүлдэг. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Маниуэль де Гутерриш 2019 оны 7-р сард болсон “НҮБ-ын Тогтвортой хөгжлийн

асуудлаарх дээд хэмжээний улс төрчдийн форум, уулзалт”-ын үеэр “Хүртээмжтэй байх, бүхнийг орхигдуулахгүй байхын чухлыг улс орнууд анхаарах нь зохилтой. Учир нь эрх тэгш бус, бусдыг орхигдуулж буй хөгжил нь тогтвортой үргэлжлэх боломжгүй” гэж уриалсан.

Тайвань дэлхийн иргэний хүлээсэн үүрэг хариуцлагаа

биелүүлэн, дэлхийн бусад улс орнуудтай тогтвортойгоор хамтран ажиллаж түншийн харилцаа тогтоохоор хичээж байна. Иймд олон улсын нийгмийн зүгээс Тайванийг НҮБ-ын системийн үйл хэрэгт оролцох эрх ашигт анхаарлаа хандуулахыг уриалж байна.

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ


ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.10.06-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

УИХ –ЫН НАМРЫН ЧУУЛГАНЫ НЭЭЛТ



Өнгөрсөн Мягмар гарагт УИХ-ын намрын ээлжит чуулган эхэллээ. Намрын чуулганы гол хэлэлцдэг асуудал бол төсөв байдаг. Энэ удаа Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт, Сонгуулийн тухай хууль гэж орсон байна. Сонгууль явуулах бүрийнхээ өмнө л хуулийг нь өөрчилдөг болсон. Энэ нь төр засгийг барьж байгаа намууд өөрсдөдөө зориулж хууль гаргаж байгаа үйлдэл гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Сонгуулийн тухай хуулийн хувьд өмнө нь Ерөнхийлөгчийн, УИХ-ын, Орон нутгийн сонгуулиудыг гурван тусдаа хуулиар зохицуулдаг байсан. Харин өмнөх УИХ-ын бүрэлдэхүүн 2015 оны 12-р сард сонгуулийн хуулиудыг нэгтгэж “Сонгуулийн тухай хууль” болгож өөрчилсөн. Дараа нь одоогийн эрх баригч нам сонгуулийн хуулийг ингэж нэг хуулиар зохицуулах боломжгүй гэж үзсээр ирсэн. Улмаар энэ хуулийг буцааж гурван тусдаа хууль болгохоор 2017 оноос идэвхтэй ярьж хуулийн төслийг боловсруулах ажлууд эхэлсэн. Энэ удаад МУ-ыг нэг сонгуулийн тойрогтой болгох гэсэн асуудлыг хэлэлцэх бололтой.

Харин Улс төрийн намын тухай хуулийг чуулган болгоноор хэлэлцэнэ гэдэг ч санаатайгаар тойрч яваад байгаа. МУ-ын хөгжилд хамгийн их саад болж байгаа, хамгийн биелэгдэхгүй байгаа хуулийг намууд өөрчлөхөөс айж байна.

Ерөнхийлөгчийн хориг

Мөн өнгөрсөн долоо хоногт Ард нийтийн санал асуулга явуулах УИХ-ын тогтоолд тавьсан Ерөнхийлөгчийн хоригийг байнгын хороодоор хэлэлцсэн. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд “Монгол улсын Ерөнхийлөгч Ард нийтийн санал асуулгыг 30 тэрбум төгрөгөөр явуулахын эсрэг байгаа. Ард нийтийн санал асуулга явуулахаар шийдсэн ч ирц бүрдэхгүй бол яах вэ. Ингэвэл хөрөнгө салхинд хийсэх болно. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг УИХ гурав, дөрөвдүгээр хэлэлцүүлгээр хэлэлцэн батлаад явах боломж бий. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг агуулгын хувьд Ерөнхийлөгчийн зүгээс эсэргүүцэн хэлэх зүйл байхгүй” гэж хэлж байсан. “Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг ард нийтийн санал асуулгаар батлах нь зөв үү” сэдвээр явагдсан Дефакто мэтгэлцээнд оролцсон хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал “Ерөнхийлөгчийн хориг гэдэг нь гүйцэтгэх эрх мэдлээс хууль тогтоох эрх мэдэлд сануулга болж буй зүйл. Хориг бол эцсийн шийд биш. Хоригийг хүлээн авахгүй байсан ч болно. Ерөнхийлөгчийн институт 1993 онд анх бий болсон. Үүнээс хойш 26 жилийн хугацаанд бүхэлчлэн болон хэсэгчлэн нийт 61 удаа хориг тавьсан байдаг. Үүний 20 хоригийг л Их хурал хүлээж авсан байдаг. Үндсэндээ талаас илүүг нь хүлээн авч байгаагүй” гэж хэлсэн. Гэвч хууль зүйн байнгын хороогоор Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авахыг дэмжээгүй бол Төрийн байгуулалтын байнгын хороо хүлээн авах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. Мөн УИХ-ын чуулганд 53 гишүүн оролцоноос 64 хувийн саналаар Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсан байна.

ИТГЭЛИЙН ЗЭЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Өнгөрсөн Лхагва гарагт УИХ-ын гишүүн Д.Оюунхорол, Н.Амарзаяа, Ё.Баатарбилэг, Х.Баделхан, Б.Батзориг, О.Батнасан, М.Билэгт, С.Бямбацогт, Д.Дамба-Очир, Д.Лүндээжанцан, Л.Мөнхбаатар, Ж.Мөнхбат нар “Итгэлийн зээл” гэгч барьцаагүй, бага хүүтэй 20 сая хүртэлх төгрөгийн зээл олгох хуулийн төсөл санаачилж өргөн барилаа. Тэд улсын хэмжээнд нийт зээлдэгчдийн 90 хувь нь 20 сая хүртэлх төгрөгийн зээл авсан бөгөөд давхардсан тоогоор 3 сая хүн энэ зээлийг авах боломж бүрдэнэ гэсэн. Мөн итгэлийн зээлийн эхний ээлжийн санхүүжилт 200-300 тэрбум төгрөг байх ба зээлийн мэдээллийн санд бүртгэлтэй 88 их наяд төгрөгийн зээлийн 0.22 хувийг эзлэж байгаа учир санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад сөрөг нөлөө үзүүлэхгүй гэв. Арилжааны банкуудаар олговол зээлийн хүү өсөх учир Төрийн банкаар дамжуулан олгоно гэж яригдаж байгаа юм байна. Санхүүжилтийн эх үүсвэрийг Төрийн тусгай сангууд, улсын төсвөөс гаргахаар тооцож байгаа гэж байна.

Энэ хүмүүс төсвийн мөнгө хаанаас гардгийг мэддэггүй бололтой. Төсөв гэдэг бол иргэдийн татвараас бүрдэж байгаа мөнгө. Төр арилжааны банкгүй байх ёстой атал Төрийн банк гэдэг байгууллага байсаар л байгаа. Төрийн банкыг хурдан хувьчлах шаардлагатай.

Дандаа үл гүйцэлдэх, эдийн засгийн ямар ч ойлголтгүй юм хийгээд байна. МУ-ын УИХ-ын гишүүд хүн амынхаа амьдралын дундаж түвшинтэй



Б.БАТЗОРИГ



М.БИЛЭГТ



Н.АМАРЗАЯА



Ё.БААТАРБИЛЭГ



Х.БАДЕЛХАН



Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



О.БАТНАСАН



С.БЯМБАЦОГТ



Л.МӨНХБААТАР



Д.ДАМБА-ОЧИР



Ж.МӨНХБАТ



Д.ОЮУНХОРОЛ

харьцуулахад дэлхийн хамгийн баян чинээлэг их хурлын гишүүд. Хуулийг өөрийн нэр хүндийг өргөж, сонгуулийн санал худалдан авахад зориулж бус асуудлыг шийдэх гэж гаргах ёстой. Асуудлыг шийдэхийн тулд түүнийг мэдэх хэрэгтэй, агуулга мөн чанарыг нь ойлгох, судлах шаардлагатай. Үүний тулд

боловсрол хэрэгтэй буюу ялангуяа гадаад хэлний мэдлэг. Хамгийн наад зах нь англи хэлгүй хүмүүс мэдээллийг бүрэн авдаггүй. Мэдэхгүйгээ мэдэхгүй хүн хамгийн хортой. УИХ-ын гишүүн хууль санаачлах эрхтэй ч зүүдэлсэн болгоноо хууль болгох гэж оролдож байгаа энэ тогтолцоогоо өөрчлөх хэрэгтэй байна даа.

ЖИНХЭНЭ ЖДҮ-ЧИД ЯЛАГДЛАА

Өнгөрсөн долоо хоногт Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн сонгон шалгаруулалтад тэнцсэн ч журам нь өөрчлөгдсөний улмаас зээлээ авч чадаагүй иргэн, ААН-үүдийн гомдол гаргасан шүүх хурал боллоо.

Хэргийг нэхэмжлэгчдийн өмгөөлөгч Ж.Эрхэмбаатар гомдол гаргагч 54 ААН дотор их хурлын гишүүн, Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд асан Б.Батзориг, их хурлын гишүүн Н.Оюундарь нарын компани байгаа. 2018 оны

2-р сарын 21-ний А29 тушаалаар манайд зээлийн эх үүсвэр байхгүй тул зээл өгч чадахгүй нь гэсэн тушаал гаргасан. Гэтэл хоёрхон сарын дараа 5-р сард А88 гэдэг тушаал гаргаж зээл өгсөн. 54 ААН-ээс зөвхөн



Б.Батзориг, Н.Оюундарь хоёрын компанид л зээл олгосон байгаа. Яагаад бусад 52 ААН-ийг ялгаад байгаа юм бэ? гэсэн. Давж заалдах шатны шүүх хурлаар Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай,

хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журамд өөрчлөлт оруулсан нь хууль бус байсан гэж үзсэн. Гэтэл Дээд шүүх Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй

болголоо. Энэ үйл явдлыг дээд шүүхийн шийдвэрт улс төрийн нөлөө орсон гэхээс илүү төрийн даалгавар байсан байх гэж харж байна.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вeeбсайтаас үзэх
боломжтой.*

Та “Дефакто Газет” цахим сонинг тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вeeбсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Ерөнхий эрхлэгч:
Дамбадаржаагийн Жаргалсайхан

Ерөнхий Редактор:
Ганбаатарын Жавзмаа

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Отгонсүрэнгийн Билгүүн
Адъяагийн Тунгалаг

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com

☎ +976 94109342

🌐 www.defacto.mn

www.jargaldefacto.com

КОРПОРЕЙТ БАЙГУУЛЛАГУУДАД ЗОРИУЛСАН
САНХҮҮГИЙН ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ



Байгууллагын бүх
төрлийн хадгаламж



Байгууллагын бүх
төрлийн санхүүжилтын
үйлчилгээ



Байгууллагад зориулсан
худалдааны санхүүжилт



Корпорейт байгууллагуудад
зориулсан бизнес карт

*Таны ухаалаг нүүдэл
Ирээдүйн баталгаа*

+ (976) 7716-9999

www.transbank.mn

secretary@transbank.mn

Шангри-Ла оффис, 15-р давхар,
Олимпын гудамж 19А,
Сүхбаатар дүүрэг 1-р хороо,
Улаанбаатар 14241,
Монгол Улс